АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангай сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/103/-НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Архангай аймаг<br>2022 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Ахлах аудитор Б.Азхүү<br>Утас: 9985-8616<br>Цахим хаяг: Azkhuub@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт ..........3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..........4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..........4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..........5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..........6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..........6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..........7
**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**..........9
3. Аудитын тайлан..........10
3.1 Ерөнхий зүйл..........10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..........10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..........11
3.4 Материаллаг байдал ..........11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..........11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..........12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..........13
3.8 Аудитын гол асуудал ..........13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..........13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..........13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..........14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал..........14
4. Аудитын илрүүлэлт ..........14
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..........15

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.23 № 64

танай ____________-ны № ____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ХАНГАЙ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГА Б.БУЛГАНЧИМЭГ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хангай сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангай сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *"/төгрөгөөр/"*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **18,891,642.93** | **20,746,842.93** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **18,891,642.93** | **20,746,842.93** |
| **35100** | **Түүхий эд материал** | **8,314,101.93** | **8,314,101.93** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 8,314,101.93 | 8,314,101.93 |
| **35400** | **Хангамжийн материал** | **10,577,541.00** | **12,432,741.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 948,420.00 | 910,020.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,629,121.00 | 10,322,721.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 0.00 | 1,200,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **523,077,098.82** | **826,098,948.72** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **523,077,098.82** | **826,098,948.72** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **518,855,098.82** | **821,876,948.72** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 535,060,924.75 | 834,455,323.75 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -31,422,557.76 | -35,612,232.12 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 16,758,423.78 | 24,704,973.78 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -13,705,678.02 | -13,835,102.76 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 763,866.76 | 763,866.76 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -763,866.76 | -763,866.76 |
| 39217 | Ном | 12,163,986.07 | 12,163,986.07 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **4,222,000.00** | **4,222,000.00** |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 4,222,000.00 | 4,222,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **541,968,741.75** | **846,845,791.65** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **31,000.00** | **1.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **31,000.00** | **1.00** |
| **41300** | **Өглөг** | **31,000.00** | **1.00** |
| **41360** | **Бусад өглөг** | **31,000.00** | **1.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 31,000.00 | 1.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **541,937,741.75** | **846,845,791.65** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **541,937,741.75** | **846,845,791.65** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 91,800,315.67 | 91,800,315.67 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **267,725,527.71** | **572,633,577.61** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 280,456,956.05 | 267,725,527.71 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -12,731,428.34 | 304,908,049.90 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 182,411,898.37 | 182,411,898.37 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **541,968,741.75** | **846,845,791.65** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **74,117,500.00** | **389,089,849.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,047,400.00** | **307,340,949.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,047,400.00** | **307,340,949.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **1,047,400.00** | **0.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 475,400.00 | 0.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 572,000.00 | 0.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 0.00 | 307,340,949.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **73,070,100.00** | **81,748,900.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **0.00** | **2,000,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 2,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **73,070,100.00** | **79,748,900.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 73,070,100.00 | 79,748,900.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **86,848,928.34** | **84,181,799.10** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **86,848,928.34** | **84,181,799.10** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **86,073,528.34** | **83,743,609.71** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **55,894,400.00** | **59,889,943.00** |
| 210101 | Үндсэн цалин | 55,894,400.00 | 59,889,943.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **7,545,700.00** | **7,956,007.61** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 5,310,000.00 | 5,571,851.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 558,900.00 | 596,424.31 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 447,200.00 | 444,901.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 111,800.00 | 160,584.06 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,117,800.00 | 1,182,246.66 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **3,573,560.00** | **8,848,700.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,240,543.00 | 2,504,297.92 |
| 210302 | Түлш, халаалт | 233,017.00 | 6,276,126.08 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 100,000.00 | 68,276.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **553,940.00** | **1,987,584.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 133,200.00 | 470,350.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 260,740.00 | 207,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 70,000.00 | 80,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 0.00 | 33,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 27,500.00 | 21,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 62,500.00 | 557,234.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 0.00 | 617,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **70,600.00** | **70,600.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 70,600.00 | 70,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **384,000.00** | **671,676.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 208,500.00 | 568,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 80,000.00 | 80,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 95,500.00 | 23,276.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **18,051,328.34** | **4,319,099.10** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 572,000.00 | 0.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 17,479,328.34 | 4,319,099.10 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **775,400.00** | **438,189.39** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **300,000.00** | **298,590.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 298,590.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **475,400.00** | **0.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 475,400.00 | 0.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **0.00** | **139,599.39** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 139,599.39 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **-12,731,428.34** | **304,908,049.90** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-12,731,428.34** | **304,908,049.90** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **91,800,315.67** | **182,411,898.37** | **280,456,956.05** | **554,669,170.09** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **91,800,315.67** | **182,411,898.37** | **280,456,956.05** | **554,669,170.09** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **-12,731,428.34** | **-12,731,428.34** |
| **10** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **91,800,315.67** | **182,411,898.37** | **267,725,527.71** | **541,937,741.75** |
| **11** | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **91,800,315.67** | **182,411,898.37** | **267,725,527.71** | **541,937,741.75** |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **91,800,315.67** | **182,411,898.37** | **267,725,527.71** | **541,937,741.75** |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 304,908,049.90 | 304,908,049.90 |
| **20** | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **91,800,315.67** | **182,411,898.37** | **572,633,577.61** | **846,845,791.65** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **73,545,500.00** | **81,748,900.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **475,400.00** | **0.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **475,400.00** | **0.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **475,400.00** | **0.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 475,400.00 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **73,070,100.00** | **81,748,900.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **0.00** | **2,000,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 2,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **73,070,100.00** | **79,748,900.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 73,070,100.00 | 79,748,900.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **73,545,500.00** | **81,748,900.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **73,545,500.00** | **81,748,900.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **72,770,100.00** | **81,170,500.61** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **55,894,400.00** | **59,889,943.00** |
| 210101 | Үндсэн цалин | 55,894,400.00 | 59,889,943.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **7,545,700.00** | **7,956,007.61** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 5,310,000.00 | 5,571,851.37 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 558,900.00 | 596,424.31 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 447,200.00 | 444,901.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 111,800.00 | 160,584.06 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,117,800.00 | 1,182,246.66 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **5,800,000.00** | **9,800,000.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,240,543.00 | 2,504,297.92 |
| 210302 | Түлш, халаалт | 2,459,457.00 | 7,227,426.08 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 100,000.00 | 68,276.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **662,400.00** | **656,950.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 66,500.00 | 66,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 340,300.00 | 334,850.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 70,000.00 | 80,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 66,300.00 | 55,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 119,300.00 | 119,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **49,000.00** | **49,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 49,000.00 | 49,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **100,000.00** | **100,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 100,000.00 | 100,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **70,600.00** | **70,600.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 70,600.00 | 70,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,648,000.00** | **2,648,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,422,500.00 | 2,422,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 80,000.00 | 80,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 145,500.00 | 145,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **775,400.00** | **578,399.39** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **300,000.00** | **438,800.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 438,800.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **475,400.00** | **0.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 475,400.00 | 0.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **0.00** | **139,599.39** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 139,599.39 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(төгрөгөөр/)*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **79,748,900.00** | **79,609,300.61** | **139,599.39** | 99.8 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **79,748,900.00** | **79,609,300.61** | **139,599.39** | 99.8 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **79,310,100.00** | **79,170,500.61** | **139,599.39** | 99.8 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **59,894,400.00** | **59,889,943.00** | **4,457.00** | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 59,894,400.00 | 59,889,943.00 | **4,457.00** | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **8,085,700.00** | **7,956,007.61** | **129,692.39** | 98.4 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 5,690,000.00 | 5,571,851.37 | **118,148.63** | 97.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 598,800.00 | 596,424.31 | **2,375.69** | 99.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 479,200.00 | 444,901.21 | **34,298.79** | 92.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 119,800.00 | 160,584.06 | **-40,784.06** | 134.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,197,900.00 | 1,182,246.66 | **15,653.34** | 98.7 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **7,800,000.00** | **7,800,000.00** | **0.00** | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,700,000.00 | 2,504,297.92 | **-804,297.92** | 147.3 |
| 210302 | Түлш, халаалт | 6,000,000.00 | 5,227,426.08 | **772,573.92** | 87.1 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 100,000.00 | 68,276.00 | **31,724.00** | 68.3 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **662,400.00** | **656,950.00** | **5,450.00** | 99.2 |
| 210401 | Бичиг хэрэг | 66,500.00 | 66,500.00 | **0.00** | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 340,300.00 | 334,850.00 | **5,450.00** | 98.4 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 70,000.00 | 80,800.00 | **-10,800.00** | 115.4 |
| 210404 | Ном, хэвлэл | 66,300.00 | 55,500.00 | **10,800.00** | 83.7 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 119,300.00 | 119,300.00 | **0.00** | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **49,000.00** | **49,000.00** | **0.00** | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 49,000.00 | 49,000.00 | **0.00** | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **100,000.00** | **100,000.00** | **0.00** | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 100,000.00 | 100,000.00 | **0.00** | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **70,600.00** | **70,600.00** | **0.00** | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 70,600.00 | 70,600.00 | **0.00** | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,648,000.00** | **2,648,000.00** | **0.00** | 100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,422,500.00 | 2,422,500.00 | **0.00** | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 80,000.00 | 80,000.00 | **0.00** | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 145,500.00 | 145,500.00 | **0.00** | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **438,800.00** | **438,800.00** | **0.00** | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **438,800.00** | **438,800.00** | **0.00** | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 438,800.00 | 438,800.00 | **0.00** | 100.0 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **79,748,900.00** | **79,609,300.61** | **139,599.39** | 99.8 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **79,748,900.00** | **79,609,300.61** | **139,599.39** | 99.8 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 79,748,900.00 | 79,609,300.61 | **139,599.39** | 99.8 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **0.00** | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | **0.00** | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **7** | **7** | **0.00** | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | **0.00** | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 3 | 3 | **0.00** | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3 | 3 | **0.00** | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **7** | **7** | **0.00** | 100.0 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 4 | 4 | **0.00** | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 3 | 3 | **0.00** | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,000,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,000,000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,000,000.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2,000,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,000,000.00 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,000,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,000,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 2,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Хангай сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азхүү гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хангай сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хангай сумын соёлын төв нь нь соёлын үйлчилгээг хөдөөгийн хүн амд хүргэн соёлын үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, үндэсний болон орчин үеийн соёл урлагийн үйл ажиллагааг ард иргэд, хүүхэд багачуудад зааж сургах, түгээн дэлгэрүүлэх чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа орон нутгийн төсвийн байгууллага байна.

Тус байгууллага нь тайлант онд "Соёлын өвийг хадгалан хамгаалж соёлын үйл ажиллагаанд иргэн гэр бүл байгууллагын оролцоог нэмэгдүүлж монгол хүнийг бага наснаас нь хүмүүнлэг, оюунлаг соёл уламжлалыг дээдэлдэг иргэн болгон төлөвшүүлэх" зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Соёлын тухай хууль
- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам";
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол "Босго үнэ шинэчлэн батлах тухай";
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хангай сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 79.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 0.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 304.9 сая төгрөгөөр буюу 56.2 хувиар өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | Хувь |
|---|---|---|---|---|
| Бараа материал | 18.8 | 20.7 | 1.9 | 10.1 |
| Үндсэн хөрөнгө | 523.1 | 826.1 | 303.1 | 57.9 |
| **Нийт хөрөнгө** | 541.9 | 846.8 | 304.9 | 56.2 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 541.9 | 846.8 | 304.9 | 56.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 541.9 | 846.8 | 304.9 | 56.2 |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл 10.1 хувиар өссөн байна.

  Бараа материалын данс нь 18.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 9.3 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 7.4 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 20.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 57.9 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 523.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 307.3 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 4.3 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч 826.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 304.9 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

*Хүснэгт 2.* Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 73.0 | 79.7 | 6.7 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 0.0 | 2.0 | 2.0 |
| Татварын бус орлого | 1.0 | 307.3 | 306.3 |
| **Үйл ажиллагааны орлого** | **74.1** | **389.0** | 314.9 |
| Цалин, шимтгэлийн зардал | 63.4 | 67.8 | 4.4 |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 5.1 | 11.4 | 6.3 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.3 | 0.6 | 0.3 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 18.0 | 4.3 | -13.7 |
| Хөрөнгө шилжүүлсэн | | | 0.0 |
| **Үйл ажиллагааны зардал** | **86.8** | **84.1** | -2.7 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-12.7** | **304.9** | 317.6 |

Хангай сумын Соёлын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 6.7 сая төгрөгөөр буюу 9.2 хувиар өссөн нь урсгал зардал нэмэгдэж батлагдсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 79.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 0.4 сая төгрөгөөр нэмж, нийт зардлыг 79.7 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 79.7 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр 79.6 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулан, 0.01 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь урсгал зардалтай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жил нэмэлт санхүүжилтээр Аймгийн ЗДТГ-аас түлш, халаалтын зардалд 2.0 сая төгрөгийг хүлээн авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Хангай сумын Соёлын төв нь 2021 онд Ковид-19 цар тахлын үеийн дэглэм, улс, аймаг, сумын онцгой комиссоос гаргасан соёл урлагийн үйлчилгээг хориглосон шийдвэрийн улмаас олон нийтийг хамарсан үйл ажиллагааг зохион байгуулаагүй, өөрийн орлогын төлөвлөгөө батлуулаагүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 3 үндсэн зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 78.5 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 79.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 79.6 сая төгрөгийг зарцуулж, 99.8 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 1.0 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.
2. Тус байгууллага нь өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгсэлгүй бөгөөд албан ажлаар явах зайлшгүй шаардлагатай тохиолдолд бусад байгууллага болон хувь хүний автмашиныг хэрэглэж шатахууны зардлыг олгодог байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.
Тус байгууллагын 2021 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 135 мэдээлэл байршуулахаас 11 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Мөн төсөв хөрөнгө зарцуулахтай холбоотой 601.1 мянган төгрөгийн 4 тушаал шийдвэрийг системд байршуулаагүй зөрчил илэрлээ.
Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, хууль журмын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

### 3.9.2 Бусад хууль тогтоомж

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.1 дэх заалтыг дагуу зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлаас 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргана гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 8.8 хувь буюу 1.0 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.
Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын *хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүлэх*

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Шилэн дансны тухай хууль, МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгах нь зүйтэй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14.3 сая төгрөгийн зөрчил илэрсний 1.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 12.7 сая төгрөгөнд зөвлөмж хүргүүллээ.

### 4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс үзэхэд 26 нэр төрлийн 12.7 сая төгрөгийн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан байна.

*Өгсөн зөвлөмж:* Иймд тухайн хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж одоо ашиглаж байгаа болон цаашид ашиглагдах хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “НББ-ийн дансны заавар”-ын 4.39-т заасны дагуу бүртгэл тайланд тусгах, харин ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдахгүй болсон хөрөнгийг ТБОНӨТХуулийн 31 дэх заалтын дагуу арга хэмжээ авч ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----оОо-----

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

*/сая төгрөгөөр/*

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Хангай сумын соёлын төв | 1 | 12.7 | | | | | | | 1 | 12.7 |
| Дүн | | 1 | 12.7 | | | | | | | 1 | 12.7 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 2 | Хангай сумын соёлын төв | 2 | 1.6 | | | | | 2 | 1.6 | | |
| Дүн | | 2 | 1.6 | | | | | 2 | 1.6 | | |
| **Нийт дүн** | | **3** | **14.3** | | | | | 2 | 1.6 | 1 | 12.7 |